

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА,
САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2023 оны 03 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 107/53

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.7, 16 дугаар зүйлийн 16.1.5, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Давхар даатгалын компанийн эрсдэлээс хамгаалах санг бүрдүүлэх, байршуулах, зарцуулах, түүнд хяналт тавих журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг 2023 оны 3 дугаар сарын 07 -ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газар /Б.Сүх-Очир/-т тус тус даалгасугай.





ДАВХАР ДААТГАЛЫН КОМПАНИЙН ЭРСДЭЛЭЭС ХАМГААЛАХ САНГ БҮРДҮҮЛЭХ, БАЙРШУУЛАХ, ЗАРЦУУЛАХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд заасан давхар даатгалын компани (цаашид “давхар даатгагч” гэх)-ийн эрсдэлээс хамгаалах санг бүрдүүлэх, байршуулах, зарцуулах, түүнд хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. “Давхар даатгалын компанийн эрсдэлээс хамгаалах сан” (цаашид “сан” гэх) гэдэгт Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 27.1.1-д заасан “Дунд түвшний эрсдэлээс хамгаалах сан”, 27.1.2-т заасан “Дээд түвшний эрсдэлээс хамгаалах сан”-г тус тус ойлгоно.

1.3. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 27.1.3-т заасан “Алдагдлаас хамгаалах сан”-г бүрдүүлэх, байршуулах, зарцуулахтай холбоотой харилцааг Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн гуравдугаар хавсралт “Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-аар зохицуулна.

Хоёр. Давхар даатгагчийн эрсдэлээс хамгаалах санг бүрдүүлэх

2.1. Энэ журмын 1.2-т заасан “Дунд түвшний эрсдэлээс хамгаалах сан” болон “Дээд түвшний эрсдэлээс хамгаалах сан”-г Үндэсний статистикийн хорооноос гаргасан сумын малын төрөл тус бүрийн хорогдлын статистик мэдээлэл, малын төрөл тус бүрийн зах зээлийн үнэлгээнд үндэслэн, актуар тооцооллоор тооцож байгуулна.

2.2. Давхар даатгагч нь санхүү, төлбөрийн чадварын байдалдаа тохирсон өөрийн хүлээж болох эрсдэлийн дээд хэмжээг тогтоох бөгөөд тухайн тогтоосон эрсдэлийн дээд хэмжээнээс давсан эрсдэлийн хариуцлагыг олон улсын давхар даатгагчид заавал даатгуулна.

2.3. Давхар даатгагч нь өөрт үлдээх эрсдэл, давхар даатгагчид шилжүүлэх эрсдэлийн хэмжээг актуар тооцоололд үндэслэн тооцно.

2.4. Олон улсын давхар даатгагчид шилжүүлэх давхар даатгалын хураамжийг даатгагчийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн, эсвэл хэсэгчлэн олон улсын давхар даатгагчид даатгаж төлсөн болон төлөхөөр тооцсон дүнгээр тодорхойлно.

Гурав. Давхар даатгагчийн эрсдэлээс хамгаалах санг хөрөнгө оруулалтад байршуулах

3.1. Давхар даатгагч нь эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалтад байршуулах төлөвлөгөөтэй байх бөгөөд тус төлөвлөгөөг давхар даатгагчийн Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/ батална. Төлөвлөгөөнд дараах эрсдэлүүдийг тооцоолж, хэрхэн удирдах бодлого, стратегийг тусгасан байна:

3.1.1.ханш ба хүүгийн эрсдэл. Зах зээлийн үнэ ба түвшинд өөрчлөлт орсноос үүдэн санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ болон ирээдүйн мөнгөн гүйлгээ хэлбэлзэх эрсдэл. Үүнд, хүүгийн түвшний эрсдэл, валютын ханшийн эрсдэл болон бусад үнийн эрсдэл хамаарна.

3.1.2.зээлийн эрсдэл. Үнэт цаас гаргагч, зээлдэгч, зуучлагч, даатгуулагч, давхар даатгагч болон баталгаа гаргагч зэрэг гуравдагч тал төлбөрийн чадваргүй болох, гэрээний хариуцлагаа биелүүлэх боломжгүй болсны улмаас давхар даатгагчид учирч болох эрсдэл. Энэ төрлийн эрсдэлд үнэт цаас төлөгдөхгүй байх, үнэт цаас гаргагчийн үнэлгээ буурах зэрэг эрсдэлүүд орно.

3.1.3.хөрөнгийн хөрвөх чадварын эрсдэл. Даатгуулагчдад их хэмжээний даатгалын нөхөн төлбөр олгох шаардлагатай тохиолдолд давхар даатгагчийн хөрөнгийн хөрвөх чадвар хүрэлцэхгүйн улмаас бэлэн мөнгөний дутагдалд орох эрсдэлтэй. Ийм төрлийн эрсдэлд хөрөнгө оруулалтад байршуулсан хөрөнгийн хөрвөх чадварын эрсдэл хамаарна.

3.1.4.хууль эрх зүйн зохицуулалтын хүрээний эрсдэл. Давхар даатгагч Даатгалын тухай хуулийн 2.1-д заасан даатгалын тухай хууль тогтоомжийг мөрдөөгүйн улмаас үүдэн гарах эрсдэл.

3.2.Давхар даатгагч нь ТУЗ-ийн хурлаар баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу давхар даатгагчийн эрсдэлээс хамгаалах санг хөрөнгө оруулалтад байршуулах бөгөөд энэ журмын 3.3-т заасан шаардлагад нийцүүлнэ.

3.3.Давхар даатгагчийн эрсдэлээс хамгаалах санг байршуулах, хөрөнгө оруулалт хийхдээ дараах ангилал, хязгаарт нийцүүлнэ:

	Хөрөнгийн ангилал	Хөрөнгө байршуулах дээд хувь	Нэгжид ногдох хөрөнгийн дээд хувь
3.3.1	Засгийн газрын өрийн хэрэгсэл	100%	100%
3.3.2	Банкны хадгаламж /Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-д заасан шаардлагыг сүүлийн 4 улирал дараалан хангасан банканд байршуулсан/	100%	35%
3.3.3	Банкны хадгаламжийн сертификат /Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-д заасан шаардлагыг сүүлийн 4 улирал дараалан хангасан банканд байршуулсан/	80%	20%
3.3.4	Төв банкны үнэт цаас /Монголбанкны мөнгөний бодлогын нээлттэй захын хэрэгсэл бөгөөд хямдруулсан хэлбэрээр арилжигдаж, тогтоосон хугацааны дараа нэрлэсэн үнээр эргэн төлөгдөх үнэт цаасыг ойлгоно/	60%	60%
3.3.5	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас /Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасныг ойлгоно/	60%	20%
3.3.6	Аймаг, нийслэлийн гаргасан өрийн хэрэгсэл	60%	20%
3.3.7	Компанийн өрийн хэрэгсэл /Үнэт цаасны зах зээлд арилжаалагддаг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-т заасан/	30%	10%
3.3.8	Ногоон бонд	20%	10%
3.3.9	Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн 1-р ангиллын хувьцаа	20%	5%

3.3.10	Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн 2-р ангиллын хувьцаа	5%	5%
3.3.11	Дотоодын банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө /Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийг хангасан банк бус санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгө/	20%	5%

3.4. Давхар даатгагчийн эрсдэлээс хамгаалах сангийн нийт дүнгээс хөрөнгө оруулалт хийсэн дүнг хассан үлдэгдлийг мөнгөн хөрөнгө буюу банкны харилцах, хугацаагүй хадгаламж, 3 сараас доош хугацаатай хадгаламж болон бэлэн мөнгө хэлбэрээр байршуулж болох бөгөөд мөнгөн хөрөнгийн 2 хүртэлх хувийг бэлэн мөнгөөр байршуулж болно.

3.5. Давхар даатгагчийн эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалтад байршуулахад Даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан хязгаарлалтыг баримтлах бөгөөд дараах этгээдүүдэд эрсдэлийн сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалт хэлбэрээр байршуулахыг хориглоно:

3.5.1. Даатгалын тухай хуулийн 4.1.12-т заасан холбогдох этгээд;

3.5.2. давхар даатгагчийн хувьцаа эзэмшигч (төрийн эзэмшил хамаарахгүй), ТУЗ-ийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, даатгалын салбарын захирал, тэдгээрийн өвөг эцэг, эмэг эх, эцэг, эх, эхнэр, нөхөр, ах, эгч, дүү, хүүхэд, бусад төрөл, садны хүн болон тэдэнд хяналтын багцаа эзэмшүүлдэг хуулийн этгээд, уг хуулийн этгээдийн хяналтын багцыг эзэмшдэг аливаа иргэн, хуулийн этгээд;

3.5.3. холбогдох этгээдтэй хэрэг, маргаан үүссэний улмаас эрх бүхий байгууллагаар хянагдаж, шалгагдаж байгаа этгээд;

3.5.4. давхар даатгагч өөрөө холбогдох этгээд гэж үзсэн бусад этгээд.

3.6. Давхар даатгагчийн эрсдэлээс хамгаалах сангаас хөрөнгө оруулалтад байршуулах дүнг тооцохдоо давхар даатгагчийн эрсдэлээс хамгаалах сангийн дүнг харгалзах хөрөнгө оруулах хувиар үржүүлж тооцно.

Дөрөв. Давхар даатгагчийн эрсдэлээс хамгаалах санг зарцуулах

4.1. Давхар даатгагчийн эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгийг зөвхөн малын индексжүүлсэн даатгалын нөхөн төлбөрт дараах байдлаар зарцуулна. Үүнд:

4.1.1. эрсдэлийн дунд түвшинд нэхэмжилсэн хохирлын нөхөн төлбөрийг “Дунд түвшний эрсдэлээс хамгаалах сан”-д ногдох дүнгээр;

4.1.2. эрсдэлийн дээд түвшинд нэхэмжилсэн хохирлын нөхөн төлбөрийг “Дээд түвшний эрсдэлээс хамгаалах сан”-д ногдох дүнгээр.

4.2. Давхар даатгагчийн эрсдэлээс хамгаалах сангийн тухайн тайлант хугацааны эцсийн үлдэгдэл нь дараагийн тайлант хугацааны эхний үлдэгдэл болно.

Тав. Давхар даатгагчийн эрсдэлээс хамгаалах санд тавих хяналт

5.1. Давхар даатгагч татан буугдсан, дампуурсан тохиолдолд малын индексжүүлсэн даатгалын бүх нөхөн төлбөрийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу олгож, хураамжийн буцаалт хийсний дараах сангийн үлдэгдлийг Компанийн тухай хуульд заасны дагуу хуваарилна.

5.2. Давхар даатгагчийн эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгө оруулалтын тайланг энэ журмын хавсралт СЗХ04170 маягтын дагуу улирал бүр гаргана.

5.3. Давхар даатгагчийн эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгө оруулалтын хагас жилийн болон жилийн эцсийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан хугацаанд, 1 болон 3 дугаар улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор албан бичгээр болон Санхүүгийн зохицуулах хорооны цахим бүртгэл (FINA программ)-д санхүүгийн тайлангийн хамт илгээнэ.

5.4. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---ooOoo---



“Давхар даатгалын компанийн эрсдэлээс хамгаалах санг бүрдүүлэх, байршуулах, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын хавсралт

МАЯГТ СЗХ04170. ДАВХАР ДААТГАГЧИЙН ЭРСДЭЛЭЭС ХАМГААЛАХ САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЙЛАН

Давхар даатгагчийн нэр

20...оны... сарын ...-ны өдөр

А	Үзүүлэлт	Мөр/ дугаар	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	Хөрөнгө оруулалт	Дүн	Эзлэх хувь
А	Б	В	1	2	3	4
1	Бэлэн мөнгө	1				
2	Банкны харилцах (=мөр 3)	2				
2.1	...банк (дансны дугаар, валют)	3				
3	Банкны хугацаагүй хадгаламж (=мөр 5)	4				
3.1	...банк (дансны дугаар, валют)	5				
4	Банкны хугацаатай хадгаламж (=мөр 7)	6				
4.1	...банк (дансны дугаар, валют)	7				
5	Банкны хадгаламжийн сертификат (=мөр 9)	8				
5.1	...банк (дансны дугаар, валют)	9				
6	Үнэт цаас (=мөр (11+12+13+14+15+16+17+18))	10				
6.1	Засгийн газрын өрийн хэрэгсэл	11				
6.2	Төв банкны үнэт цаас	12				
6.3	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	13				
6.4	Аймаг, нийслэлийн гаргасан өрийн хэрэгсэл	14				
6.5	Компанийн өрийн хэрэгсэл	15				
6.6	Ногоон бонд	16				
6.7	Монголын хөрөнгийн биржийн 1 ангиллын хувьцаа	17				
6.8	Монголын хөрөнгийн биржийн 2 ангиллын хувьцаа	18				
7	Тухайн давхар даатгалын компанийн холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө (=мөр 20)	19				
7.1	...ББСБ	20				
8	НИЙТ ДҮН (=мөр (1+2+4+6+8+10+19))	21				100%

(төгрөгөөр)

ТАЙЛАН ГАРГАСАН:

.....
(албан тушаал) (гарын үсэг)

.....
(овог нэр)

Тамга тэмдэг

Тайлан гаргасан хугацаа:

20... оны ... сарын ... өдөр